



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 16 өдөр

Дугаар 4/с

Хархорин сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээг
бусдад шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4, 38.6 дахь заалт, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалаар батлагдсан "Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам"-ын 8.1.3 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын 2, 3 дугаар багт байрлах 3 нэгж талбарын 57500м² газрыг эзэмшигчийн хүсэлтийн дагуу хавсралтад зааснаар шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

2.Газар эзэмшигч Б.Сарангэрэл, Хархорин-Интернэшнл ХХК, "Азтай мазаалай" ХХК, М.Бундхүү нарт газар эзэмших эрхийн гэрчилгээ олгож, гэрээ байгуулж, улсын бүртгэлд бүртгэхийг газрын даамал (А.Норпил), (Ч.Баттулга) нарт даалгасугай.

3.Газрын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн холбогдох заалтыг мөрдөж ажиллахыг газар эзэмшигчид үүрэг болгосугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Засаг даргын 2020 оны А/18 дугаар захирамжийн Б.Наянжинтай холбогдох хэсэг, 2016 оны А/37 дугаар захирамжийн Хархорин-Интернэшнл ХХК-тай холбогдох хэсэг, газар эзэмших эрхийн 000029769, 0000239684 дугаартай гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА  Б.БАТ-ЭРДЭНЭ

